

НИСЛЭГИЙН ЖУРАМ БОЛОВСРУУЛАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2020.07.22

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдөр баталсан “ИНЕГ-ын харьяа Нислэгийн журам боловсруулалтын албаны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” №16/20 дугаар удирдамжийн хүрээнд тус нэгжийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны менежер П.Батсайхан, аудитор А.Мөнх-Эрдэнэ, Т.Саранчимэг, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Оюут нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд НЖБА-ны 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгаж, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Ажилтанд удаан жил ажилласны нэмэгдэл олгох тухай Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудад 2020-2021 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний заалт болон ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журамд заасан заалтууд хоорондоо зөрүүтэй байгаагаас цаашид олон ажилтны хөдөлмөр цалин хөлсний тооцоололд зөрүү үүсэх нөхцөл бүрдсэн байна. Тус албаны 5 ажилтанд удаан жил ажилласны цалингийн нэмэгдлийг Хамтын гэрээнд заасан хувиас зөрүүтэй бодож олгосон.

Хөдөлмөрийн сайдын А/114 дүгээр тушаалын 1.в-д заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг хавсран хариуцах ажилтныг томилоогүй.

2020 оны 06 дугаар сарын ажлын цагийн тооцоог буруу гаргаснаас цалин зөрүүтэй бодогдсон байна.

Нислэгийн журам зохиох хэсэг болон шалгалтын нислэгийн хэсгийн ажилтнууд нь шаардлагатай боловсон хүчний сургалтад зохих зааврын дагуу хангалттай хамрагдаагүй байгаа нь НЖБА-ны удирдлагууд нь ажилтнуудаа мэргэшүүлэх, тэдгээрийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх талаар холбогдох журмын дагуу идэвх санаачилгатай ажиллахгүй байгаатай холбоотой байна.

НЖБА-ны шалгалтын нислэгт тавигдах шаардлага нь ИНД-ээр зохицуулагдаагүй байна.

Нислэгийн журам боловсруулалтын албаны “Үйл ажиллагааны заавар”-ын ЖУ-101-ийн Сургалтын журмын 4.4.1 дэх заалт алдаатай боловсруулагдсан.

Тус албаны “Үйл ажиллагааны заавар” ЖУ-307-ын 4.9.1-д заасны дагуу ...Аудитаар шалгуулагч нь аудитаар илэрсэн үл тохиролд дүн шинжилгээ хийн залруулах эсхүл сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудит дууссанаас хойш 14 хоногийн дотор гарган Аюулгүй ажиллагаа, чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан болон аудитын багийн ахлагчид хүргүүлнэ..., 4.9.2-т...Төлөвлөгөөний дагуу явуулсан арга хэмжээний тайланг Аюулгүй ажиллагаа, чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан болон аудитын багийн ахлагчид өгнө..., 4.9.3-т ...Аудитын багийн ахлагч тайлантай танилцаж явуулсан арга хэмжээ нь үр дүнтэй, хангалттай болсон гэж үзсэн тохиолдолд уг үл тохирлыг хаана... гэж заасны дагуу дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангалттай түвшинд гаргаагүй.

НЖБА-ны “Үйл ажиллагааны заавар”-ын ЖУ-304-т заасны дагуу хэрэглэлийн нислэгийн журам зохиох үйл ажиллагаа, шалгалтын нислэгийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн

тохируулга, баталгаажуулалт зэрэг албаны үйл ажиллагааг бүхэлд нь хамруулан эрсдэлийн үнэлгээ, судалгаа шинжилгээ хийгээгүй.

ДАА-наас 2019 онд НЖБА-нд хийгдсэн дотоод аудит, хяналт шалгалтаар Нислэгийн журам боловсруулах албаны бүтээгдэхүүнийг журам зохиогч болон хэрэглэгч талууд оролцсон аюулгүй ажиллагааны зөвлөлөөр хэлэлцсэний дараа хүлээн зөвшөөрдөг байх ёстой гэж дүгнэж, зөвлөмж хүргүүлсэн бөгөөд энэхүү зөвлөмж биелээгүй.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар тус албанд нийт 11 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА